



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 678

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүйн туслалцааны төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 69,075,000.00 (жаран есөн сая далан таван мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 17,839,000.00 (арван долоон сая найман зуун гучин есөн мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Л.Уянга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 4 дугаар сарын 12 ны өдрийн
678 дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ,
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГӨ (автомашин)

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох балансын нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)
1	Автомашин-Киа оптима, 41-82 УБҮ /арал-кнау411bk5315927/	5/14/2015	1	69,075,000.00 (жаран есөн сая далан таван мянга)	17,839,000.00	17,839,000.00	4
	Нийт дүн			69,075,000.00 (жаран есөн сая далан таван мянга)		17,839,000.00 (арван долоон сая найман зуун гучин есөн мянга)	